

## 5-р хичээл: Тохинуулал

Та энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл богино хэсэгт хуваан зааж болно. Хичээлийг заахдаа тухайн орон нутгийнхаа нөхцөл байдал, чуулга эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө хэрэгцээ, нас, ойлголтод тулгуурлаарай.

### ЕСҮС ХРИСТ БИДЭНД ХЭРХЭН ТОХИНУУЛАХЫГ ЗААСАН

Чуулга, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдэд Есүс Христ бол тохинууллын үлгэр жишээ гэдгийг ойлгоход туслахын тулд та тэднийг Түүний сургаал, үйлчлэлийн үлгэр жишээний талаар ярилцахад урьж болно (Лук 10:25–37; 3 Нифай 17:5–10-ыг үзнэ үү). Тохинуулал гэдэг нь Аврагчийн адил бусдыг халамжлахыг хэлдэг гэдгийг тайлбарла. Хэн нэгэн танд хэзээ тохинуулсан бэ? Мөн энэ нь танд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? Биднийг чуулга болон ангийнхаа гишүүдэд тохинуулахаар хичээж чармайхад Христийн үлгэр жишээ хэрхэн нөлөөлдөг вэ? Харин биднийг бусдад тохинуулахаар хичээж чармайхад Христийн үлгэр жишээ хэрхэн нөлөөлдөг вэ?

### БИД ЭРГЭН ТОЙРОНДОО БУЙ ХҮМҮҮСТ ТОХИНУУЛЖ ЧАДНА

Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдэд чуулга эсвэл ангийнхаа гишүүдэд хэрхэн тохинуулах талаар сүнслэг өдөөлт хүлээн авахад нь туслахын тулд тэдний хүн нэг бүрийг нэрээр нь авч хэлэлцэхэд урь (нарийн бичиг Member Tools аппликэйшнаас эсвэл тойргийн бичиг хэргийн ажилтнаас ангийн нэрсийн жагсаалтыг авч болно). Дараах асуултууд тусалж болох юм. Үүнд:

- Бид тэдний тухай юу мэдэх вэ?
- Тэдэнд ямар онцгой давуу талууд болон бэрхшээлүүд байдаг вэ?
- Тэдэнд туслахын тулд бид юу хийж чадах вэ (жишээ нь, үйлчлэл, үйл ажиллагаа, ням гаргийн хурал цуглаанаар дамжуулан)?

Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдээс чуулга, ангийн гишүүдийг давуу тал, авьяас чадвараа ашиглан чуулга эсвэл ангийнхаа хүмүүст болон бусдад тохинуулахад нь хэрхэн урамшуулж болох талаар бодож үзэхийг хүс.

Чуулгын эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс хийхээр өдөөгдсөн зүйлээ хэрэгжүүлэхэд урь. Хамгийн сүүлийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал цуглааны үеэр гаргасан төлөвлөгөөгөө хянаж, өөрчлөн, шинэ төлөвлөгөөндөө оруулахыг тэднээс хүсэж болох юм. Тэднийг хувь хүмүүсийн талаар хуваалцсан хувийн чухал мэдээллийг нууцлах ёстой гэдгийг ойлгосон эсэхийг шалгаарай.

### НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- *Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь*, 21-р бүлэг, ChurchofJesusChrist.org
- 2 Коринт 6:4–7; Мозая 18:8–9; Сургаал ба Гэрээ 84:106
- “We Are Strong Together” видео бичлэг